

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2014 оны 5-р сарын 28-ны байдлаар*


2014 оны 5-р сарын 28-ны байдлаар хүнсний гол нэрийн барааны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 0.9 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 0.1 хувиар буурсан байв.

Махны дундаж үнэ: 2014 оны 5-р сарын 28-ны байдлаар үхрийн ястай махны үнэ өмнөх сарынхаас 5.0 хувь, үхрийн цул мах 4.0 хувь, ямааны мах 2.3 хувь, хонины ястай мах 0.7 хувь, адууны мах 0.1 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногийнхоос үхрийн цул махны үнэ 2.1 хувь, үхрийн ястай махны үнэ 1.9 хувь, хонины ястай махны үнэ 0.7 хувиар өсч, адууны махны үнэ 1.6 хувиар буурч, ямааны махны үнэ өөрчлөлтгүй байна.

2014 оны 5-р сарын 28-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7680 төгрөг, үхрийн /ястай/ мах 8785 төгрөг, үхрийн цул мах 10890 төгрөг, адууны мах 6605 төгрөг, ямааны мах 5780 төгрөгийн үнэтэй байв(Зураг 1).


Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ



Гурилын үнэ: 2014 оны 5-р сарын 28-ны байдлаар дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ өмнөх сарынхаас 0.9 хувь, дээд зэргийн савласан гурил өмнөх сарынхаас 2.6 хувь, 1-р зэргийн гурилын үнэ өмнөх сарынхаас 11.3 хувь, 2-р зэргийн гурилын үнэ 6.6 хувиар өссөн байна. Харин өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2014 оны 5-р сарын 28-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сарынхаас 0.2 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. Харин элсэн чихэр өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байлаа (Зураг2).

Зураг2



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2014 оны 5-р сарын 28-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад луувангийн үнэ 11.9 хувь, байцааны үнэ 3.8 хувь, манжингийн үнэ 0.9 хувь, төмсний үнэ 0.5 хувиар өсч, сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхоос луувангийн үнэ 3.1 хувиар өссөн бол бусад хүнсний ногооны үнэ өөрчлөлтгүй байлаа.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2014 оны 5-р сарын 28-ны байдлаар өмнөх сарынхаас савласан /1 литрийн/ сүүний үнэ 9.4 хувиар буурч, задгай сүүний үнэ 0.7 хувиар өсч, “Элекстер” /0.5 л/ савласан сүүний үнэ өөрчлөлтгүй байна, өмнөх 7 хоногийнхоос “Элекстер” /0.5 л/ савласан сүүний үнэ 5.2 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 9.0 хувиар буурч, задгай сүүний үнэ 5.2 хувиар өслөө.

Ургамлын тосны үнэ өмнөх сарынхаас 0.2 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй, өндөгний үнэ өмнөх сарынхаас 2.5 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй, цөцгийн тосны үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, мах, цагаан будаа, малын сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

Гурилын үнэ: 2014 оны 5-р сарын 28-ны байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 680-1500 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Гурилын үнэ өмнөх 7 хоногийнхоос Увс, Орхон, Хөвсгөл, Өмнөговь аймагт 30-100 төгрөгөөр өссөн байна.

Дорнод аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 680 төгрөг байхад, Булган аймагт 1500 төгрөг байгаа нь өндөр үнэ байна.

Махны үнэ: 2014 оны 5-р сарын 28-ны байдлаар хонины махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Хөвсгөл аймагт 500 төгрөгөөр өсч, Говь-Алтай, Увс, Архангай, Орхон, Дархан-Уул, Өмнөговь аймагт 170-500 төгрөгөөр буурсан байна.

Хонины махны үнэ Хөвсгөл аймагт 8500 төгрөг байгаа нь өндөр бөгөөд Баян-Өлгий аймагт 6500 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байв.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Ховд, Дорнод аймагт 200-500 төгрөгөөр өсч, Баян-Өлгий, Архангай, Орхон, Дархан-Уул, Төв аймагт 170-1000 төгрөгөөр буурсан байна. Үхрийн махны үнэ Дорнод аймагт 9500 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ бөгөөд Баян-Өлгий аймагт 6000 төгрөгөөр худалдаалагдсан нь хямд үнэ байв.

Ямааны махны үнэ Баян-Өлгий, Өвөрхангай, Хөвсгөл, Өмнөговь аймагт 50-500 төгрөгөөр өсч, Говь-Алтай, Ховд, Орхон, Дархан-Уул аймагт 150-500 төгрөгөөр буурсан байна. Ямааны мах Баян-Өлгий аймагт хямд буюу 6000 төгрөг байхад Өмнөговь аймагт 7650 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ байна.

Малын сүүний үнэ: 2014 оны 5-р сарын 28-ны байдлаар малын сүү аймагт 800-3000 төгрөгийн үнэтэй худалдаалагдсан байна. Сүүний үнэ Баян-Өлгий, Увс, Булган, Орхон, Хөвсгөл, Дархан-Уул аймагт 100-300 төгрөгөөр буурсан байна. Өмнөговь аймагт хамгийн /3000 төг/ өндөр үнэтэй байна.

Цагаан будаа, элсэн чихрийн үнэ: 2014 оны 5-р сарын 28-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх 7 хоногийнхоос бүх аймагт өөрчлөлтгүй байна. Аймгуудад цагаан будаа 1 кг нь 2000-2400 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх 7 хоногийнхоос Дархан-Уул, Төв аймагт 50-100 төгрөгөөр өсч, Өмнөговь аймагт 70 төгрөгөөр буурсан байна. Элсэн чихэр 1 кг нь 1530-2000 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.